

ГОВЬСҮМБЭР АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

“ОРОН НУТГИЙН 2023 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛД
ӨГӨХ САНАЛ, ДҮГНЭЛТ”

АУДИТЫН КОД: ГСА-2022/14-6-ШТА-ТД

Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын
газрын дарга, тэргүүлэх аудитор:
Б.Сарантуяа, Утас: 70543156
Цахим хаяг: Sarantuyab@audit.gov.mn

Аудитын менежер: Г.Наранбаяр,
Утас: 70543179
Цахим хаяг: Naranbayarg@audit.gov.mn

Ахлах аудитор: Б.Дарханбат, Утас: 70543179
Цахим хаяг: darkhanbatb@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт
мэдээллийг дараах хаягаар авна уу.
Цахим хуудас: www.audit.mn

АГУУЛГА

АГУУЛГА 2

ТОВЧИЛСОН ҮГС 3

Төсвийн төсөлд орлого нэмэгдүүлэх боломжтой эх үүсвэрийг
бүрэн судлаж тусгаагүй байна. 7

1.1 Төсвийн төсөлд татварын орлогыг өмнөх оны авлагад
үндэслэн нэмэгдүүлж төлөвлөсөн байна. 7

1.2 Эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалж татварын
орлогын нэр төрлийг нэмэгдүүлэх боломж хязгаарлагдмал
байна. 9

Төсвийн төсөлд төсвийн зарлагыг боломжит хэмжээнд бууруулж
төлөвлөөгүй, хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээг хуульд
тогтоомжид нийцүүлэн үр ашгийг нэмэгдүүлэх шаардлагатай
байна. 11

2.1 Төсвийн төсөлд зарлагыг төрийн хэмнэлтийн бодлогод
нийцүүлэн боломжит хэмжээнд бууруулж, арвилан хэмнэлттэй
төлөвлөөгүй байна. 11

2.2 Төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын ажлын
урьдчилсан тооцоо судалгаа, төлөвлөлтийг сайжруулах
шаардлагатай байна. 13

Дүгнэлт

Зөвлөмж

Шалгагдагч байгууллагын санал тайлбар

Шалгагдагч байгууллагын саналд өгсөн тайлбар

Тайланг бэлтгэсэн:

Говьсүмбэр аймаг дахь
Төрийн аудитын газар

Дарга, тэргүүлэх аудитор
Б.Сарантуяа

Аудитын менежер

Г.Наранбаяр

Ахлах аудитор
Б.Дарханбат

Аудитор
С.Батцэцэг

Аудитын тайлан,
дүгнэлттэй холбоотой
асуудлаар нэмж тодруулах,
асууж лавлах зүйл байвал
70543156, 70543179
дугаарын утсаар харилцана
уу.

ХАЯГ:

Сүмбэр сум 3-р баг,
Нутгийн удирдлагын
ордон, 205 тоот

2022 оны 11 дүгээр сар

ТОВЧИЛСОН ҮГС

ААНБ	Аж ахуй нэгж байгууллага
ААНОАТ	Аж ахуй нэгжийн орлогын албан татвар
АДБОУС	Аудитын дээд байгууллагуудын олон улсын стандарт
АИТХ	Аймгийн Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
АМАТ	Ашигт малтмалын ашигласны төлбөр
БОАЖГ	Байгаль орчин аялал жуулчлалын газар
БХНСАХ	Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээ
ЗДНХ	Засаг даргын нөөц хөрөнгө
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ЗДҮАХ	Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
МУЕА	Монгол Улсын Ерөнхий аудитор
НТБТ	Насан туршийн боловсролын төв
ОАТ	Орлогын албан татвар
ОНХО	Орон нутгийн хөрөнгө оруулалт
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ТАБ	Төрийн аудитын байгууллага
ТАХ	Төсөл арга хэмжээ
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
УИХ	Улсын их хурал
ҮАХ	Үйл ажиллагааны хөтөлбөр
ХБТХОХ	Хөгжлийн бодлого төлөвлөлт хөрөнгө оруулалтын хэлтэс
ХХОАТ	Хувь хүний орлогын албан татвар
ЦСҮТ	Цөм сүргийн үржлийн төв
ЦХБТАОАТ	Цалин, хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогын татвар
ЭЗНХҮЧ	Эдийн засаг нийгмийг хөгжүүлэх үндсэн чиглэл

АУДИТЫН ЗОРИЛТ, ХАМАРСАН ХҮРЭЭ, АРГА ЗҮЙ, ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ

Аудит хийх
үндэслэл,
бүрэн эрх:

Аудитыг УИХ-ын төсвийн байнгын хорооны 2021 оны 06 дугаар тогтоол, МУЕА-ын 2022 оны А/12 дугаар тушаал, Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газрын 2022 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө болон Төрийн аудитын тухай хуулиар тодорхойлсон бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэлээ.

Аудитын зорилт:

Аймгийн Засаг даргаас ИТХ-д өргөн мэдүүлсэн 2023 оны төсвийн төсөлд төсвийн орлого нэмэгдүүлэх, төсвийн зарлагыг бууруулах, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх талаар дүгнэлт гаргаж, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлэхэд аудитын зорилго чиглэгдэнэ.

Аудитын зорилтыг хангахын тулд дараах дэд зорилтуудын дагуу аудитыг гүйцэтгэсэн.Үүнд:

- Төсвийн төсөлд төсвийн орлогыг боломжит хэмжээнд нэмэгдүүлж төлөвлөсөн үү?
- Төсвийн төсөлд төсвийн зарлагыг боломжит хэмжээнд бууруулж, санхүүжилтийг үр нөлөөтэй ТАХ-д зарцуулахаар төлөвлөсөн үү?

Дараах хууль эрх зүйн актын холбогдох заалтуудыг аудитын шалгуур үзүүлэлт болгон ашиглав.

Аудитад ашигласан
шалгуур үзүүлэлт:

- ✓ Төрийн аудитын тухай
- ✓ Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хууль
- ✓ Төсвийн тухай хууль
- ✓ Төрийн хэмнэлтийн тухай хууль
- ✓ Татварын хуулиуд
- ✓ Засгийн газрын 2019 оны 312, 2021 оны 160 дугаар тогтоол
- ✓ Сангийн сайдын 2019 оны А/282, 2021 оны А/86 дугаар тушаал
- ✓ Холбогдох бусад хууль тогтоомж, хөтөлбөр, гэрээ, эрх зүйн актууд
- ✓ Аймаг, сумын ИТХ-ын тогтоол, Засаг даргын захирамж, холбогдох шаардлагатай хууль, дүрэм, журам

Аудитын хамарсан
хүрээ:

Аймгийн Засаг даргаас Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн барьсан орон нутгийн 2023 оны төсвийн төсөл, түүний орлого, зарлагын тооцоо судалгаа, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөлтийн баримт материал, аймгийн ЗДТГ болон төсвийн төлөвлөлтөд оролцсон бусад байгууллагыг хамрууллаа.

Аудитын арга зүй:

Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУС 3000-3100, Гүйцэтгэлийн аудитын үндсэн ойлголтын удирдамж УДИР 3910, УДИР 3920, Монгол Улсын Төрийн аудитын стандарт, MNS 6817-5:2020 “Гүйцэтгэлийн аудитын зарчим”, MNS 6817-7:2020 “Гүйцэтгэлийн аудитын стандарт” Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “ТАБ-аас аудит хийх журам”, түүнд нэмэлт өөрчлөлт оруулсан Монгол Улсын Ерөнхий аудиторов 2021 оны А/81 дүгээр тушаал, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2021 оны А/69 дугаар тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал”, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2022 оны А/67 дугаар тушаалаар батлагдсан “Төсвийн төсөлд дүгнэлт гаргах аргачлал”-ыг ашиглан гүйцэтгэсэн.

Аудит хийх багийн
бүрэлдэхүүн,
хугацаа:

Аудитыг дарга, Тэргүүлэх аудитор Б.Сарантуяа хянан удирдаж, үе шатны хяналтыг аудитын менежер Г.Наранбаяр хэрэгжүүлж, ахлах аудитор Б.Дарханбат, аудитор С.Батцэцэг төлөвлөгөө, хөтөлбөрийн дагуу хийж гүйцэтгэлээ.

Аудитын талбарын ажлыг 2022 оны 11 дүгээр сарын 23-ны өдрөөс эхлүүлж, тайланг Тэргүүлэх аудиторовн тушаалаар баталгаажуулан шалгагдагч байгууллага болон холбогдох эрх бүхий албан тушаалтанд 2022 оны 12 дугаар сарын 01-ний өдөр хүргүүллээ.

Хүндрэл бэрхшээл:

Аудитыг гүйцэтгэх хугацаанд 2 орон тоо дутуу ажиллаж байгаагаас аудитын багт хүний нөөцийн дутагдал үүссэн, Орон нутгийн төсвийн төсөлд дүгнэлт гаргах явцад аймгийн Засаг даргаас төсвийн төслийг өөрчлөн дахин өргөн барьсан нь аудитыг төлөвлөсөн хугацаанд гүйцэтгэхэд хүндрэл учруулж байсан. Мөн сүүлийн 4 жилийн хугацаанд аймгийн ЗДТГ-ын ХБТХОХ-ийн дарга 4 удаа солигдож, аймгийн хөгжлийн бодлогыг тодорхойлох бодлогын хэлтэс тогтвор суурьшилгүй ажиллаж байгаа нь алдаа зөрчил жил бүр давтагдан гарах шалтгаан болж байна. Мөн төсвийн төсөлд дүгнэлт гаргах явцад 2 удаа өөрчлөлт орсон бөгөөд 2022.11.25, 2022.11.28-нд өөрчлөлт оруулсан.

Аудитад 2022.11.25-ны өдөр орсон өөрчлөлтийг тусгасан. Цаашид төсвийн төсөлд дүгнэлт гаргуулахаар ирүүлэхдээ эцсийн байдлаар боловсруулагдсан төсвийн төсөл ирүүлэх шаардлагатай байна.

ҮНДСЭН МЭДЭЭЛЭЛ

Говьсүмбэр аймаг дахь Төрийн аудитын газраас “Төрийн аудитын тухай” хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2 “..., түүнчлэн аймаг, нийслэлийн Засаг даргаас тухайн шатны иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлсэн жилийн төсвийн төсөлд төсвийн орлого нэмэгдүүлэх, төсвийн зарлагыг бууруулах, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх талаар дүгнэлт гаргаж, ... аймаг, нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд хүргүүлэх” гэж заасан бүрэн эрхийн дагуу аймгийн Засаг даргаас иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн мэдүүлсэн орон нутгийн 2023 оны төсвийн төсөлд санал, дүгнэлт боловсруулан хүргүүлж байна.

Монгол Улсын Их Хурлаас 2022 оны 11 дүгээр сарын 11-ны өдөр Монгол Улсын 2023 оны төсвийн тухай хууль хэлэлцэн баталсан.

Аймгийн Засаг даргаас орон нутгийн 2023 оны төсвийн төслийг Төрийн аудитын байгууллагад 2022 оны 11 дүгээр сарын 18-ны өдрийн А/1479 дугаартай албан бичгээр 2022 оны 11 дүгээр сарын 21-нд ирүүлсэн байна.

Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулиар Говьсүмбэр аймгийн орон нутгийн төсвийн 2023 оны нийт орлогын эх үүсвэрийг 14,878.9 сая төгрөгөөр баталсан байна. Үүнд:

- ❖ Төсвийн суурь орлогыг 8,134.4 сая
- ❖ Орон нутгийн хөгжлийн сангийн орлогын шилжүүлэг 4,632.4 сая
- ❖ Улсын төсвөөс авах санхүүгийн дэмжлэг 2,112.1 сая төгрөг байна.

Дүрслэлийн товъёг

<i>№</i>	<i>Тайлбар</i>	<i>Хуудасны дугаар</i>
<i>Хүснэгт 1</i>	<i>Орлогын төлөвлөгөөний харьцуулалт</i>	<i>7</i>

Хүснэгтийн товъёг

<i>№</i>	<i>Тайлбар</i>	<i>Хуудасны дугаар</i>
<i>Хүснэгт 1</i>	<i>Суурь орлогын нэмэгдүүлэх санал</i>	<i>7</i>
<i>Хүснэгт 2</i>	<i>Аймгийн 2022, 2023 оны төсвийн орлогын хязгаар</i>	<i>9</i>
<i>Хүснэгт 3</i>	<i>Аймгийн 2023 оны төсвийн зарлага</i>	<i>11</i>
<i>Хүснэгт 4</i>	<i>Аймгийн 2022 оны хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээ</i>	<i>14</i>
<i>Хүснэгт 5</i>	<i>Бодлогын баримт бичигт нийцээгүй, хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээ</i>	<i>15</i>
<i>Хүснэгт 6</i>	<i>Урсгал зардлын тооцоо, орон нутгийн төсөвт үзүүлэх нөлөөлөл, өмчлөлийн асуудлын талаар дүгнэлт гаргаагүй хөрөнгө оруулалтын арга хэмжээ</i>	<i>15</i>

БҮЛЭГ 1


Төсвийн төсөлд орлого нэмэгдүүлэх боломжтой эх үүсвэрийг
бүрэн судалж тусгаагүй байна.

1.1 Төсвийн төсөлд татварын орлогыг өмнөх оны авлагад үндэслэн нэмэгдүүлж төлөвлөсөн байна.

Төсвийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.3-т зааснаар Төсвийн ерөнхийлөн захирагч нь тухайн жилийн төсвийн төслийг Сангийн яамнаас хянан ирүүлсэн хязгаарт багтаан боловсруулахаар заасан.

Говьсүмбэр аймгийн 2023 оны орон нутгийн төсвийн суурь орлого, зарлагыг 2,112.2 сая төгрөгөөр алдагдалтай төлөвлөж, улсын төсвөөс санхүүгийн дэмжлэг авахаар батлагдсан бөгөөд энэ нь өмнөх оноос 7.0 хувиар буурсан байна. Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангаас 4,632.4 сая төгрөгийн орлогын шилжүүлгийг хуваарилсан байна.

Дүрслэл №1 Орлогын төлөвлөгөөний харьцуулалт



УИХ-аас баталсан орон нутгийн татварын орлогын дүнг сүүлийн 4 жилд аймгийн ИТХ-аас жил бүр нэмэгдүүлэн баталсан байна. Тухайлбал 2020 онд 4.5%, 2021 онд 0.3%, 2022 онд 29.2%-иар тус тус нэмэгдүүлсэн бол 2023 онд 11.9%-иар нэмэгдүүлэх санал оруулсан байна.

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.8-д жилийн төсвийн хязгаарыг тухайн жилийн төсөв боловсруулахад баримтлах орлогын доод, зарлагын дээд хэмжээ гэж заасан бөгөөд аймгийн жилийн суурь орлогыг 8,134.4 сая төгрөгөөр хянасныг 9,104.4 төгрөг болгож, 970.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн төсвийн төсөлд тусган ирүүлсэн байна.

Аймгийн 2023 оны төсвийн төсөл дэх суурь орлогыг Сангийн яамны баталсан хязгаартай харьцуулахад дараах байдалтай байна.

Хүснэгт №1

(сая.төг)

№	Орлогын нэр төрөл	Сангийн яам хянасан	2023 оны төсөв	Зөрүү
1	НИЙТ ОРЛОГО БА ТУСЛАМЖИЙН ОРЛОГО	8,134.4	9,104.4	970.0
2	ТӨСВИЙН НИЙТ ОРЛОГО	7,202.8	8,042.8	970.0
3	ТАТВАРЫН ОРЛОГО	7,202.8	8,042.8	840.0
4	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	931.6	1,061.6	130.0

Дээрх орлогоос татварын орлогыг 970.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэхдээ ус рашаан ашигласны төлбөрийн орлогын татварыг 140.0 сая, ЦХБТАОАТ-ыг 600.0 сая, үйл ажиллагааны орлогын татварыг 50.0 сая, ХХОАТ-ын буцаалт 100.0 сая, татварын бус орлого болох төсөвт байгууллагын өөрийн орлогыг 70.0 сая, торгуулийн орлогыг 60.0 сая төгрөгөөр тус тус нэмэгдүүлж, үл хөдлөх хөрөнгийн албан татварын орлогыг 80.0 сая төгрөгөөр бууруулахаар тооцсон байна.

Монгол Улсын 2023 оны Төсвийн тухай хуулиар Говьсүмбэр аймгийн 2023 оны төсвийн нийт орлогын эх үүсвэрийг 14,879.0 сая төгрөгөөр баталсан бөгөөд аймгийн Засаг даргаас 2023 төсвийн төсөлд орлогын эх үүсвэрийг **2,982.2 сая** төгрөгөөр нэмэгдүүлж, 17,861.2 сая төгрөгөөр батлуулахаар аймгийн ИТХ-д өргөн барьсан байна. Орлогын эх үүсвэрийг дараах байдлаар нэмэгдүүлэн төлөвлөжээ. Үүнд:

1. Суурь орлого: **Нийт 970.0 сая**

- ❖ Татварын орлого-900.0 сая
- ❖ Татварын бус орлого-70.0 сая

2. Бусад орлого: **Нийт 2,012.2 сая**

- ❖ 2022 оны татварын орлогын төлөвлөгөөнөөс давсан орлого – 400.0 сая
- ❖ Орон нутгийн төсвийн байгууллагуудын 2022 оны зардлын хэмнэлт - 781.3 сая
- ❖ ОНХС, ОНХО, АЗС - он дамжин хийгдэх ажлуудын эхний үлдэгдлээс - 830.9 сая /ОНХО-555.8 сая, АОНХС-242.9 сая, Автозамын сан-32.2 сая/

Орон нутгийн төсвийн орлогыг шинээр батлагдсан хууль тогтоомж, төсвийн орлого бүрдүүлэлтэд нөлөө үзүүлэх үр дагавар бүхий шийдвэрийн нөлөөллийг тооцох чиглэлээр бодлого баримтлан дараах 2 төрлийн хуулийн хүрээнд орлогыг нэмэгдүүлэх боломж байна. Үүнд:

- Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2¹, 28 дугаар зүйлийн 28.5², Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 49 дүгээр тогтоолын дагуу аймгийн ИТХ хуулиар олгогдсон эрх үүргийнхээ хүрээнд түрээсийн хэмжээнд өөрчлөлт оруулж, шинэчлэн тогтоох боломж байна. Уг тогтоолоор түрээсийн төлбөрийн доод жишиг үнийг баталсан байна. Аймгийн хэмжээнд орон сууцны түрээслэгчийн хувьд зах зээлийн үнээс 11 дахин бага үнээр түрээсэлж байгаа бөгөөд метр квадратыг аймгийн төвд 5000, сумын төвд 3000 төгрөгөөр шинэчлэн тогтооход **65.6 сая**, ААНБ-ын түрээсийн хувьд метр квадратыг 7000 төгрөгөөр шинэчлэн тогтооход **98.3 сая**, нийт **163.9 сая** төгрөгөөр нэмэгдүүлэх боломжтой байна.
- Хог хаягдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.7.1³ 9 дүгээр зүйлийн 9.1.3⁴-т 9.1.4⁵ заасны дагуу сумдад хог хаягдлын үнэ тарифыг шинэчлэн тогтоосноор орлого нэмэгдэх боломжтой байна. Шивээговь, Баянтал сумдууд 2014 онд батлагдсан үнэ тарифыг мөрдөж байгаа бол Сүмбэр сумын ИТХ-ын 2022 оны 7 сарын 07-ны өдрийн 03 дугаар тогтоолоор үнэ тарифыг шинэчлэн баталсан боловч Хууль зүйн яамаар хянагдаагүй байна.

¹ 11.2/ төрийн өмчийн эд хөрөнгийн анхан шатны бүртгэл, тооллого, тайлан тэнцэл гаргах ажлыг зохион байгуулж удирдах, төрийн өмчийн эд хөрөнгийн ашиглалтад хяналт тавьж, түүний үр ашгийг дээшлүүлэх арга хэмжээ авах

² 282 5. Төрийн өмчийн түрээсийн төлбөрийг улсын төсөвт оруулна. Уг төлбөр тухайн эд хөрөнгийг худалдан авах үнийн төлбөрт үл хамаарна.

³ 8.7.1. хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг тооцох аргачлалыг байгаль орчны асуудал эрхэлсэн төрийн захиргааны төв байгууллагатай хамтран баталж, хэрэгжилтийг хангуулах;

⁴ 9.1.3 “Энгийн хог хаягдлыг цэвэрлэх, ангилах, цуглуулах, тээвэрлэх, дахин боловсруулах, сэргээн ашиглах, устгах, булилах журмыг баталж, мөрдүүлэх”;

⁵ 9.1.4 энэ хуулийн 8.7.2-т заасан аргачлалын дагуу нийтийн эдэлбэр газрын хог хаягдлыг цэвэрлэх, энгийн хог хаягдлыг булилах зардлын нэгж тарифыг батлах”

1.2 Эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалж татварын орлогын нэр төрлийг нэмэгдүүлэх боломж хязгаарлагдмал байна.

Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.8-д зааснаар Сангийн яамнаас орлогын доод хязгаарыг хянаж ирүүлдэг. Аймгийн 2023 оны орлогын төлөвлөлтийг Сангийн яамны хянасан дүнтэй харьцуулбал татварын орлогын доод хязгаарыг баримтлан төлөвлөсөн байна.

Аймгийн Засаг даргаас өргөн мэдүүлсэн орон нутгийн 2023 оны төсвийн Сангийн яам аймгийн 2023 оны төсвийн жилийн суурь орлогыг 8,134.4 сая төгрөгөөр хянасныг 9,104.4 төгрөг болгож, 970.0 сая төгрөгөөр нэмэгдүүлэн төлөвлөсөн байна.

Аймгийн 2022, 2023 онуудын төсвийн орлогын хязгаарыг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №02

“Аймгийн 2022, 2023 оны төсвийн орлогын хязгаар”

/сая.төг/

Орлогын нэр төрөл	Сангийн яамны хянасан 2022 оны төсөв	Аймгийн 2022 оны батлагдсан төсөв	Сангийн яамны хянасан 2023 оны төсөв	Аймгийн 2023 оны төсвийн төсөл	Өмнөх оны төсөвтэй харьцуулсан зөрүү	СЯ-ны хянасан дүнгээс нэмэгдүүлэн төсөвлөсөн дүн
ОРОН НУТГИЙН НИЙТ ОРЛОГО, ТУСЛАМЖИЙН ДҮН	7,026.6	9,082.3	8,134.4	9,104.4	22.1	970.0
ОРОН НУТГИЙН ТӨСӨВТ ТӨЛӨРҮҮЛЭХ ОРЛОГО	7,026.6	9,082.3	8,134.4	9,104.4	22.1	970.0
ТАТВАРЫН ОРЛОГО	6,335.0	8,118.0	7,202.8	8,042.8	-75.2	840.0
ААНОАТ / 40%/	160.0	160.0	251.6	251.6	91.6	-
Авто тээврийн болон өөрөө явагч хэрэгслийн албан татвар	130.0	130.0	140.0	140.0	10.0	-
Үйлдвэрлэл үйлчилгээний зориулалтаар ашигласан усны төлбөр	420.0	581.0	450.0	590.0	9.0	140.0
Дуудлага худалдаа		10.0	250.0	250.0	240.0	-
ЦХБТАОАТ	4,200.0	5,171.6	4,604.0	5,204.0	32.4	600.0
Үйл ажиллагааны орлого	40.0	40.0	50.0	100.0	60.0	50.0
Суутгагчийн хувь хүнд олгосон ОАТ	300.0	300.0			-300.0	-
Улсын тэмдэгтийн хураамж	130.0	111.2	130.0	80.0	-31.2	-50.0
Хөрөнгө борлуулсны ОАТ	50.0	150.0	100.0	100.0	-50.0	-
ХХОАТ-ын буцаалт	-350.0	-263.8	-500.0	-400.0	-136.2	100.0
Үл хөдлөх хөрөнгийн албан татвар	480.0	740.0	817.3	817.3	77.3	-
Бууны албан татвар	5.0	4.8	5.0	5.0	0.2	-
Хог хаягдлын үйлчилгээний хураамж	120.0	162.0	135.0	135.0	-27.0	-
Түгээмэл тархацтай АМАТ	20.0	20.0	20.0	20.0	-	-
Агнуурын нөөцийн төлбөр	20.0	20.0			-20.0	-
Газрын төлбөр	360.0	389.0	499.8	499.9	110.9	-
Иргэдийн хадгаламжийн хүүгийн орлого	250.0	248.0	250.0	250.0	2.0	-
Малын тоо, толгойд ногдох албан татвар		144.2			-144.2	
ТАТВАРЫН БУС ОРЛОГО	691.6	964.3	931.6	1,061.6	97.3	130.0
Түрээсийн орлого	60.0	60.0	60.0	60.0	-	

ТБ-ын өөрийн орлого	31.6	64.0	31.6	101.6	37.6	70.0
Торгуулийн орлого	600.0	840.3	840.0	900.0	59.7	60.0

2023 онд өмнөх оны орлогын төлөвлөгөөнөөс 6 төрлийн орлого 572.4 сая төгрөгөөр буурч, 13 төрлийн татварын орлого 730.7 сая төгрөгөөр нэмэгдэж, нийт дүнгээрээ 22.1 сая төгрөгөөр нэмэгдэж, татварын орлогыг өмнөх оны түвшинд төлөвлөсөн байна.

Орлогын төлөвлөгөөний өөрчлөлтөд аж ахуй нэгжийн орлогын албан татварын орлогын 40 хувийг аймаг, нийслэлийн төсөвт төвлөрүүлдэг болсон, шүүхийн шийдвэр буцаан олгогдох магадлалтай улсын тэмдэгтийн хураамжийн буцаалт, цалин, хөдөлмөрийн хөлс, шагнал, урамшуулал болон тэдгээртэй адилтгах хөдөлмөр эрхлэлтийн орлогын албан татвар, суутгагчийн ХХОАТ, хөрөнгө борлуулсны орлогын албан татвар, хүү торгуулийн орлогыг гүйцэтгэлээр тооцсон зэрэг нөхцөл байдлууд нөлөөлсөн байна.

САНАЛ:

1. Төсвийн орлого бүрдүүлэлтэд нөлөө үзүүлэх үр дагавар бүхий хууль эрхийн актуудыг батлан гаргаж 2023 оны төсвийн төсөлд орлогыг 163.9 сая төгрөгөөр нэмэгдүүлэх

БҮЛЭГ 2

Төсвийн төсөлд төсвийн зарлагыг боломжит хэмжээнд бууруулж төлөвлөөгүй, Төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын ажлын урьдчилсан тооцоо судалгаа, төлөвлөлтийг сайжруулах шаардлагатай байна.

2.1 Төсвийн төсөлд зарлагыг төрийн хэмнэлтийн бодлогод нийцүүлэн боломжит хэмжээнд бууруулж, арвилан хэмнэлттэй төлөвлөөгүй байна.

ТЕЗ бөгөөд аймгийн Засаг даргаас Иргэдийн Төлөөлөгчдийн Хуралд өргөн барьсан төсвийн төсөл нь Төсвийн тухай хууль болон холбогдох журмын шалгуур, шаардлагыг бүрэн хангаж чадаагүй байна. Мөн өмнөх оны төсвийн төсөлд өгсөн дүгнэлтэд дурдагдсан зарим алдаа зөрчлүүд давтагдан гарсан байна.

Аймгийн 2023 оны төсвийн нийт зарлага 14,879.0 сая төгрөгөөр хянагдан батлагдаж ирсэн байна. Үүнд:

- ❖ Орон нутгийн суурь зарлага 10,246.6 сая
- ❖ ОНХС-гийн зарлага 4,632.4 сая

УИХ-аас батлагдаж ирсэн төсвийн нийт зарлагыг ТЕЗ-аас нийт 2,982.2 сая төгрөгөөр нэмэгдүүлж, нийт зарлагыг 17,861.2 сая төгрөгөөр батлуулахаар төсвийн төслийг ирүүлсэн байна.

Төсвийн нийт зарлагын бүтцийг хүснэгтээр харуулбал:

Хүснэгт №3

“Аймгийн 2023 оны төсвийн зарлага”

/сая.төг/

Төсвийн зарлагын нэр	УИХ-аас хянасан төсөв	2023 оны төсвийн төсөл	Зөрүү
Орон нутгийн суурь зардал	10,246.6	11,776.1	1,529.5
ОНХС-гийн зардал	4,632.4	4,875.4	243.0
ОНХО-ын зардал		1,209.7	1,209.7
Нийт дүн	14,879.0	17,861.2	2,982.2

2023 оны орон нутгийн төсвийн нийт зарлагад дараах байдлаар өөрчлөлт оруулан төлөвлөж, санал ирүүлсэн байна. Үүнд:

1.Төсвийн суурь зарлага: -1,785.9 сая

1. Аймгийн ИТХ – 396.4 сая
2. Аймгийн ЗДТГ- 855.0 сая
3. Сумдын ИТХ-11.6 сая
4. Сумдын ЗДТГ-432.5 сая
5. СХДАА-42.3 сая
6. НТБТөв-80.0 сая
7. ЦСҮТ-(-15.0) сая
8. Орон нутгийн Өмчийн газар – 63.6 сая төгрөг

9. Усан спорт, сургалтын төв - 100.0 сая
10. Сум дундын ойн анги – 90.3 сая
11. Боловсрол, соёл, эрүүл мэнд, БОАЖГ-ын тогтмол зардал,-(-351.0 сая)
12. Хот тохижилтын зардал(-120.0) сая
13. БОАЖГ-100.0 сая
14. Стандартчлал хэмжил зүйн хэлтэс-100.0 сая

2. Хөрөнгө оруулалт, хөтөлбөр, төсөл, арга хэмжээ: - 1,196.3 сая

1. Орон нутгийн хөрөнгө оруулалт – 844.8 сая
2. Аймгийн ОНХС - 242.9 сая
3. БХНСАХ-56.5
4. Авто замын сан-52.1

Орон нутгийн 2023 оны төсөвт тусгагдсан хууль дүрэм, журамд нийцээгүй нийт **595.2 сая** төгрөгийн зарлагыг бууруулах, хууль тогтоомжид нийцүүлэх дараах саналыг гаргаж байна.

Төсвийн зарлагыг бууруулах санал

1. Аймгийн ИТХурал

- Төсвийн тухай хуулийн 6 дугаар 6.4.1⁶, 31.1.3⁷, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2.3⁸, Засгийн газрын 2019 оны 445-р тогтоолоор батлагдсан “Орон нутгийн төсвийн суурь зарлагыг тооцох аргачлал”-ын 3.4.4⁹-т заасны дагуу төлөвлөөгүй 5.6 сая төгрөгийн тээвэр шатахуун, 8.0 сая төгрөгийн дотоод албан томилолт, зочин төлөөлөгч хүлээн авах, 7.0 сая төгрөгийн биеийн тамир, уралдаан тэмцээний зардал, 25.0 сая төгрөгийн бараа үйлчилгээний зардал **нийт 45.6 сая** төгрөгийн зардлыг бууруулах

2. Аймгийн ЗДТГазар

- Дотоод албан томилолтын зардлын тайлант оны хүлээгдэж буй гүйцэтгэлээс илүү гарсан 4.2 сая, орон нутгийн төсвийн суурь зарлагыг тооцох аргачлалын дагуу төлөвлөөгүй тээвэр шатахууны 9.6 сая, аймгийн Засаг даргын нөөц хөрөнгийн зориулалт, чиг үүрэгт хамааралгүй төрийн бус байгууллагын үйл ажиллагааны зардлыг санхүүжүүлэх 35.0 сая, **нийт 48.8 сая** төгрөгөөр зардлыг бууруулах

3. Политехник коллеж, Ерөнхий боловсролын 3,4,5-р сургууль

- 2023 оны төсвийн төсөлд эрчим хүчний зохицуулах зөвлөлийн 2021 оны 470-р тогтоол, аймгийн ЭХЗЗ-ийн 2021 оны 04, 05 тогтоол болон Эрчим хүчний зохицуулах хорооны 2018 оны 292 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан “Аж ахуйн харилцааны дүрэм”-ийн 5.3.1¹⁰, Монгол Улсын MNS6781:2019 стандартын 4.1¹¹-д заасныг зөрчин дотуур байрны халаалтыг м3 болон төсвийн байгууллагын үнэ тарифаар тооцож төлөвлөснөөс шалтгаалж Политехник коллеж-67.8 сая, 3-р

⁶ төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах

⁷ жилийн төсвийн хязгаарт багтаасан байх

⁸ сургалт, семинар, хурал, зөвлөгөөнийг цахим хэлбэрээр зохион байгуулж, бичиг хэрэг, тээвэр шатахуун, дотоод албан томилолт болон холбогдох бусад зардлыг хэмнэх

⁹ тээвэр шатахууны зардлын хэмжээг дараахь томъёогоор тооцно:

¹⁰ Аливаа барилга байгууламж, орон сууц нь дулааны тоолуур суурилдаагүй бол дулааны эрчим хүчний төлбөр тооцоог энэхүү дүрэмд заасны дагуу эзэлхүүн болон талбайн хэмжигдэхүүнээр гэрээний дагуу тооцно. Орон сууцны барилгыг ахуйн зориулалтаар нь ашиглаж, хүн амьдарч байгаа бол талбайн хэмжигдэхүүнээр, үүнээс бусад нөхцөлд эзэлхүүнээр тооцно.

¹¹ Ерөнхий боловсрол эзэмшихийн тулд оршин суугаа газраас сургуульд тогтмол явах боломжгүй суралцагчдын амьдрах зориулалт бүхий сургуулийн бүрэлдэхүүн хэсэг

сургууль-4.7 сая, 4-р сургууль-9.3 сая, 5-р сургууль-25.4 сая **нийт 107.8 сая** төгрөгийн халаалтын зардлыг илүү төлөвлөсөн тул тогтмол зардлыг бууруулах

4. Орон нутгийн хөгжлийн сан

- “Хяналт шинжилгээ үнэлгээний мэдээллийн цахим санг нэвтрүүлэх” **100.0 сая** төгрөгийн өртөгтэй арга хэмжээ нь орон нутгийн хөгжлийн сангийн чиг үүрэгт хамааралгүй, иргэдийн санал авч эрэмбэлэгдээгүй нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5¹², 60 дугаар зүйлийн 60.3.6¹³, Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 6 дугаар зүйлийн 6.3.2¹⁴-т заасантай нийцэхгүй байх тул зардлыг бууруулах
- ОНХС-нд тусган хэрэгжүүлэх 2 арга хэмжээний зардлаас **нийт 3.5 сая** төгрөгийг шагнагч урамшуулал хэлбэрээр зарцуулахаар төсвийн төсөлд тусгасан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5⁷, 60 дугаар зүйлийн 60.3.6⁸, Сангийн сайдын 2021 оны 86-р тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.7.3¹⁵, 4.7.5¹⁶-т гэж заасныг зөрчсөн тул зардлыг бууруулах

5. Стандартчлал хэмжилзүйн хэлтэс

- Стандартчлал хэмжил зүйн хэлтсийг байгуулах эрх бүхий албан тушаалтны шийдвэр гараагүй байхад **100.0 сая** төгрөгийн урсгал зардал төлөвлөсөн нь Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төсвийн тухай хуульд нийцэхгүй тул зардлыг бууруулах

2.2 Төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын ажлын урьдчилсан тооцоо судалгаа, төлөвлөлтийг сайжруулах шаардлагатай байна.

Орон нутгийн 2023 оны төсөвт тусгагдсан 2,100.6 сая төгрөгийн төсөл арга хэмжээний үр ашгийг дээшлүүлэх дараах саналыг гаргаж байна.

Төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх санал

Говьсүмбэр аймгийн 2023 оны орон нутгийн төсвийн төсөлд ОНХО, ОНХС, Авто замын сан, Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас санхүүжүүлэх нийт 4,475.9 сая төгрөгийн 54 хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

ТЕЗ-аас хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх орлогын эх үүсвэрийг нэмэгдүүлэхдээ 2022 оны үндсэн тэнцлийн ашгаас 56.5 сая, 2023 оны орлого нэмэгдүүлэх эх үүсвэрээс 20.0 сая, 2022 оны ОНХО-ийн он дамжих ажил 844.9 сая, ОНХС-ийн дансны үлдэгдэл 242.9 сая, Автозамын сангийн он дамжих ажил 32.2 сая төгрөгийг дараа онд шилжүүлэн зарцуулахаар нийт 1,196.5 сая төгрөгөөр өөрчлөлт оруулж, батлуулахаар санал оруулсан байна.

Хүснэгт №4

“Аймгийн 2022 оны хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээ”

(сая.төг)

¹² Батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах

¹³ Нийтийн эрх ашигт нийцээгүй үйл ажиллагаа

¹⁴ Орон нутгийн удирдлагыг хэрэгжүүлэх чиг үүрэгт зарцуулахаар төлөвлөхгүй байх

¹⁵ Нийтийн эрх ашигт нийцээгүй үйл ажиллагаа

¹⁶ Аливаа аж ахуйн нэгж байгууллага, иргэдэд буцалтгүй тусламж, дэмжлэг, тэтгэмж урамшуулал

№	Хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээ	Орон нутгийн хөгжлийн сан	Орон нутгийн хөрөнгө оруулалт	Авто замын сан	БХНСАХ	Нийт
1	Хөрөнгө оруулалт	1,329.3	1,038.2	212.2	28.7	2,608.3
2	Их засвар	245.0	50.0	260.6		555.5
3	Тоног төхөөрөмж	220.0	107.4			327.3
4	Зураг төсөв	150.0	14.2			164.1
5	Хөтөлбөр, төсөл арга хэмжээ	397.0		222.2	201.3	820.4
Дүн		2,341.3	1,209.7	695.0	230.0	4,475.9

Нийт санхүүжүүлэхээр тооцсон төсөвт өртгийн 3,491.3 сая төгрөг буюу 78%-ийг хөрөнгө оруулалтын ажилд зарцуулахаар төлөвлөжээ.

Хөрөнгө оруулалтын бус арга хэмжээ

1. Аймгийн ЗДНХөрөнгө:

- Аймгийн ЗДНХ-ийн чиг үүрэгт хамааралгүй “Аймаг, орон нутагт нэн шаардлагатай мэргэжлээр ирж тогтвор, суурьшилтай ажиллах албан хаагчдыг дэмжих” арга хэмжээг 150.0 сая төгрөгөөр төлөвлөсөн боловч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, төсвийн тооцоо судалгааг ирүүлээгүй. *(Санал-Хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, тооцоо судалгааг гаргаж АИТХ-д танилцуулах)*

2. Аймгийн ЗДТГазар:

- Нийтийн тээврийн зардалд 35.0 сая төгрөгийг төлөвлөсөн боловч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, төсвийн тооцоо судалгааг гаргаж ирүүлээгүй.- *(Санал-Хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, тооцоо судалгааг гаргаж аймгийн ИТХ-д танилцуулах)*

Хөрөнгө оруулалтын арга хэмжээ-Орон нутгийн хөгжлийн сан

Сангийн яамнаас орон нутгийн хөгжлийн нэгдсэн сангийн орлогын шилжүүлгийг 4,632.4 мянган төгрөгөөр баталсан бөгөөд сумдад 2,534.0 сая төгрөгийг хуваарилж, 2,098.4 сая төгрөгөөр аймгийн ОНХС-г баталсан байна. Аймгийн ОНХС нь 2023 онд дансны үлдэгдэл 242.9 сая төгрөгөөр эх үүсвэр нэмэгдэж, 2,341.3 сая төгрөгөөр батлуулахаар аймгийн ИТХ-д өргөн барьсан байна.

2023 оны орон нутгийн хөгжил сангаар нийт 2,341.3 сая төгрөгийн 23 хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөжээ. 2022 оноос 2023 онд дамжин хэрэгжих 122.6 сая төгрөгийн 1 ажил байна.

Төсвийн төсөлд тусгасан хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээ нь холбогдох эрх зүйн акттай нийцэж буй эсэхийг шалгахад дараах асуудлууд илэрлээ. Үүнд:

1. Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр болон хөрөнгө оруулалтын хөтөлбөр, 2023 оны жилийн төлөвлөгөө зэрэг дунд хугацааны бодлогын баримт бичигт тусгагдаагүй **нийт 122.0 сая төгрөгийн 2** төсөл, арга хэмжээ байна. Үүнд:

Хүснэгт №5 “Бодлогын баримт бичигт нийцээгүй, хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээ”

(сая.төг)

№	Төсөл, арга хэмжээний нэр	Мөнгөн дүн	Тайлбар
---	---------------------------	------------	---------

1	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд усалгааны худаг гаргах, хашаа барих ажил	112.0	Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4.1.1-т заасныг зөрчсөн.
2	Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн агуулахын зураг төсөв боловсруулах ажил	10.0	
Нийт		122.0	

(Санал-Бодлогын баримт бичигт нийцүүлэх)

- Шинээр хэрэгжүүлэх 1,206.6 сая төгрөгийн 6 ажлыг гүйцэтгэж хүлээн авсны дараах урсгал зардлын тооцоо, орон нутгийн төсөвт үзүүлэх нөлөөлөл, өмчлөлийн асуудлын талаар урьдчилсан дүгнэлт гаргаагүй байна.

Хүснэгт №6 “Урсгал зардлын тооцоо, орон нутгийн төсөвт үзүүлэх нөлөөлөл, өмчлөлийн асуудлын талаар дүгнэлт гаргаагүй хөрөнгө оруулалтын арга хэмжээ”

(сая.төг)

№	Төсөл, арга хэмжээний нэр	Мөнгөн дүн	Тайлбар
1	Сүмбэр сумын 1-р баг тээвэрчдийн өргөн чөлөөний гудамж талбайн гэрэлтүүлэг	126.1	Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4.1.6-т заасантай нийцээгүй.
2	Шинээр олгогдсон газарт цахилгаан татах ажил /Тэрэгт/	300.0	
3	Нарангийн гэр хороололд цахилгаан татах ажил	586.3	
4	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд усалгааны худаг гаргах, хашаа барих ажил	112.0	
5	Аймгийн төвд явган хүний замыг нэмэгдүүлэх ажил	70.0	
6	Агаарын чанарын мэдээлэл авах цэгийн цахилгаан хангамжийн ажил	12.1	
Нийт		1,206.6	

(Санал-Урсгал зардлын тооцоо, төсөвт үзүүлэх нөлөөлөл, өмчийн асуудлын талаар урьдчилсан дүгнэлт гарган танилцуулах)

- 2023 оны ОНХС-гийн хөрөнгөөр “Төрийн байгууллагуудад шаардлагатай техник тоног төхөөрөмж худалдан авах” арга хэмжээг **190.0 сая** төгрөгөөр төлөвлөсөн бөгөөд уг арга хэмжээний төлөвлөлтийн баримт, тооцоо судалгаа нь бүрэн бус төрийн байгууллагуудаас ирүүлсэн хүсэлтийг хэрэгцээ шаардлагын эрэмбэлээгүй тул дээрх зөрчлийг арилган АИТХ-д танилцуулах

Хөрөнгө оруулалтын арга хэмжээ-Орон нутгийн хөрөнгө оруулалт

2023 оны орон нутгийн хөрөнгө оруулалтаар нийт 1,209.7 сая төгрөгийн 10 хөрөнгө оруулалт, зураг төсөв боловсруулах ажил төлөвлөжээ. Үүнээс 844.9 сая төгрөгийн 9 ажил нь 2022 оны орон нутгийн хөрөнгө оруулалтын төлөвлөгөөнд батлагдсан боловч бүрэн хэрэгжээгүй ажлууд байна.

Төсвийн суурь зарлагад батлагдсан **364.8 сая** төгрөгийн “Орон нутгийн өмчийн байгууллагуудын засварын ажил” нь батлагдсан зураг төсөл, төсөвгүй байгаа нь Төсвийн тухай

хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4¹⁷-т заасныг зөрчсөн тул шаардлагатай тооцооллыг хийж аймгийн ИТХ-д танилцуулах шаардлагатай байна.

Авто замын сан

2023 онд аймгийн Автозамын сангийн хөрөнгөөр 5 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр 694.9 сая төгрөгийг төлөвлөжээ.

Өмнөх аудитаар “Авто замын сангаас 2019 онд хэрэгжүүлсэн автозамын засварын ажлын гүйцэтгэгчээр “Бодьтулга” ХХК шалгарч, 110.0 сая төгрөгийн өртөг бүхий ажлын гэрээг байгуулж, хэрэгжүүлсэн боловч одоог хүртэл ажлыг бүрэн хүлээж аваагүйгээс 32.1 сая төгрөгийн үлдэгдэл санхүүжилтийг олгоогүй, өглөгөөр бүртгэсэн байгаа тул төсвийн хөрөнгийн үр ашгийг сайжруулах” гэсэн санал зөвлөмж өгсөн боловч хэрэгжүүлж ажиллаагүй, 2023 оны шилжих ажилд дахин төлөвлөгдсөн тул дээрх зөрчлийг арилгаж, төсвийн хөрөнгийн үр ашгийг нэмэгдүүлэх шаардлагатай байна.

Байгаль хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээ

Сангийн яамнаас 2023 оны орон нутгийн төсвийн суурь зарлагад тус арга хэмжээний зардлыг 253.5 сая төгрөгөөр хянасныг тэнцлийн ашгаас 56.5 сая төгрөгөөр нэмэгдүүлж, 310.0 сая төгрөгөөр төсвийн төсөлд тусгажээ. Үүнээс аймагт 230.0 сая, Сүмбэр суманд 46.7 сая, Шивээговь суманд 25.7 сая, Баянтал суманд 7.6 сая төгрөгийг тус тус хуваарилсан байна.

Аймгийн байгаль орчин нөхөн сэргээх арга хэмжээний зардлаас 2023 онд шинээр хэрэгжүүлэх 1 хөрөнгө оруулалт, 14 төсөл, арга хэмжээнд нийт 230.0 сая төгрөгийг зарцуулахаар төлөвлөсөн байна.

Гүйцэтгэлийн аудитаар орон нутгийн 2023 оны төсвийн орлогыг нэмэгдүүлэх 163.9 сая, зарлагыг бууруулах 405.2 сая, төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх 2,100.6 сая, нийт 2,669.7 сая төгрөгийг санал гаргаж аймгийн ИТХ, ТЕЗ-д хүргүүлээ.

¹⁷ Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.

ДҮГНЭЛТ

Аудитын явцад цуглуулсан нотлох зүйлс, аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлт хийж байна.

Бүлэг-1

- 1 Төсвийн төсөлд татварын орлогыг өмнөх оны авлагад үндэслэн нэмэгдүүлж төлөвлөсөн байна.
- 2 Эдийн засгийн нөхцөл байдлаас шалтгаалж татварын орлогын нэр төрлийг нэмэгдүүлэх боломж хязгаарлагдмал байна.

Бүлэг-2

1. Төсвийн төсөлд зарлагыг төрийн хэмнэлтийн бодлогод нийцүүлэн боломжит хэмжээнд бууруулж, арвилан хэмнэлттэй төлөвлөөгүй байна
2. Төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэх хөрөнгө оруулалтын ажлын урьдчилсан тооцоо судалгаа, төлөвлөлтийг сайжруулах шаардлагатай байна.

ЗӨВЛӨМЖ

Аудитын нотлох баримт, аудитын дүгнэлтэд үндэслэн дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг дор дурдсан байгууллага, албан тушаалтанд зөвлөж байна.

Аймгийн Засаг даргад:

1. Орон нутгийн өмчийн түрээсийн төлбөр, хог хаягдлын үйлчилгээний хураамжийн хэмжээг шинэчлэн тогтоох, татварын суурийг нэмэгдүүлэх замаар орлого нэмэгдүүлэх санаачилга гаргах
2. Зураг төсөвгүй, тооцоолол тодорхойгүй төсөл, арга хэмжээг төлөвлөхгүй байх
3. Төсвийн төсөлд дүгнэлт гаргуулахаар ирүүлэхдээ аливаа өөрчлөлтийг багтаасан эцсийн байдлаар бэлтгэсэн төсвийн төслийг ирүүлэх

Санхүү, төрийн сангийн хэлтэст:

4. Төсвийн төслийг Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалаар батлагдсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах аргачлал-ын дагуу бэлтгэх
5. Төсвийн төслийг өргөн барьснаас хойш төсвийн төсөлд дүгнэлт өгөх явцад тоон мэдээллийг өөрчлөхгүй байх, тооцооллын алдаа гаргахгүй байх

Зөвлөмжийн хэрэгжилтийг 2023 оны 11 дүгээр сарын 25-ны өдрийн дотор Төрийн аудитын байгууллагад албан ёсоор ирүүлэх

ШАЛГАГДАГЧ БАЙГУУЛЛАГЫН САНАЛ



ГОВЬСҮМБЭР АЙМГИЙН ЗАСАГ ДАРГА

42015 Говьсүмбэр аймаг, Сүмбэр сум, 3 дугаар баг,
Найрамдал хотхон, Утас/факс: (976) 7064 3005,
И-мэйл: zdg.gsa@ymail.com, Вэбсайт: www.govisumber.gov.mn


2022.12.01 № 8/1526
ТАНАЙ _____-ны № _____-г

АЙМГИЙН ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАРТ

Аймгийн 2023 оны төсвийн төсөлд үр ашгийг
дээшлүүлэх, зардал бууруулах, орлого нэмэгдүүлэх
тухай танай байгууллагаас ирүүлсэн саналд дараах
хариу тайлбарыг бэлтгэн хүргүүлэв.

Хавсралт хуудастай.

ОРЛОГЧ ДАРГА



БАНХБАЯР

428-300959

Орон нутгийн 2023 оны төсвийн үр ашгийг дээшлүүлэх саналд өгсөн харму тайлбар

№	Байгууллагын нэр	Зөрчил	Үндэслэл	Мөнгөн дүн	Санал	Харму тайлбар
1	АЗДТГ	АЗДНХ-ийн чиг үүрэгт хамааралгүй "Аймаг, орон нутагт нэн шаардлагатай мэргэжлээр ирж тогтвор, суурьшилтай ажиллах албан хаагчдыг дэмжих" арга хэмжээг 150.0 сая төгрөгөөр төлөвлөсөн, хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, төсвийн тооцоо судалгааг ирүүлээгүй.	Төсвийн тухай хуулийн 6.4.1, 31.1.3, Сангийн сайдын 2021 оны 61-р тушаалын хавсралтаар батлагдсан журмын 2.1	150,000,000	Төлөвлөгөө хөтөлбөрийг боловсруулж хүрэх үр дүн, шалгуур үзүүлэлтийг тодорхой болгох	Тус зардлыг Засаг даргын нөөц санд бус АЗДТГ-ын Төрөөс иргэдэд үзүүлэх бусад тэтгэмж, дэмжлэг зардалд тусган Шинэ сэргэлтийн бодлогын хүрээнд хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг боловсруулан ажиллах болно. 2023 оны 1 дүгээр улиралд багтаан төлөвлөгөөг боловсруулан, задаргааг батлуулна.
		Нийтийн тээврийн зардалд 35.0 сая төгрөгийг төлөвлөсөн боловч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө, төсвийн тооцоо судалгааг гаргаж ирүүлээгүй	Төсвийн тухай хуулийн 6.4.1	35,000,000		2 ширхэг цахилгаан автобусны жолоочийн цалин НДШ-ийн зардалд 25.0 сая төгрөг, бусад урсгал зэсвэр болон цэнэглэлт, цахилгааны зардалд 10.0 сая төгрөг тус тус зарцуулахаар тооцсон.
2	ОНХС	2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр, аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, 2023 оны жилийн төлөвлөгөө зэрэг дүнд хугацааны бодлогын баримт бичигт тусгагдаагүй нийт 142.0 сая төгрөгийн 3 төсөл, арга хэмжээ байна.	Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 4.1.1	142,000,000	Бодлогын баримт бичигт өгцүүлэх	1.Тэрбум мод үндэсний хөдөлгөөн нь Монгол Улсын Ерөнхийлөгчийн санаачилгаар 2022 оноос эхлэн хэрэгжиж байна. Үүнтэй холбогдуулан Аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөртэй уялдуулан төсөвлөсөн. Шинэ сэргэлтийн бодлого болон Тэрбум мод үндэсний хөдөлгөөний бодлогын хүрээнд Аймгийн Засаг даргын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөрт тодотгол хийхээр төлөвлөж байна. 2.Гамшгаас хамгаалах сургалт, арга зүйн төв байгуулах зурал төсвийн ажлыг АЗДУАХ-ийн 4.3.11 дэх авалтын дагуу төсөвлөсөн 3. Орон нутгийн өмчийн ашиглалт хамгаалалтыг сайжруулах зорилгоор агуулах барих ажлыг АЗДУАХ-ийн 4.4.3 дахь авалтын дагуу төсөвлөсөн.
3	ОНХС	Шивээр хэрэгжүүлж 1,206.6 сая төгрөгийн 6 ажлыг гүйцэтгэж хүлээн авсны дараах урсгал зардлын тооцоо, орон нутгийн төсөвт үзүүлэх нөлөөлөл, өмчлөлийн асуудлын талаар урьдчилсан дүгнэлт гаргаагүй байна.	Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 4.1.6	1,206,587,100	Журмын дагуу төсөвт үзүүлэх нөлөө, өмчлөлийн асуудлын талаар урьдчилсан дүгнэлт гаргах	Энэхүү ажлын хүрээнд холбогдох урсгал зардлын асуудлыг тухай бүр жил жилийн төсөвт батлуулан төлөвлөхөөр тооцож ажиллах байгаа болно.
4	АЗС	Авто замын сангаас 2019 онд хэрэгжүүлсэн автозамын засварын ажлын гүйцэтгэгчээр "Бодьтулга" ХХК шалгарч, 110.0 сая төгрөгийн өртөг бүхий ажлын гэрээг байгуулж, хэрэгжүүлсэн боловч одоог хүртэл ажлыг бүрэн хүлээж аваагүйгээс 32.1 мянган төгрөгийн үлдэгдэл санхүүжилтийг олгоогүй, өглөгөөр бүртгэсэн	Төсвийн тухай хуулийн 6.4.8, 16.5.5	32,189,500	Хэрэгжигүй байгаа гэрээний үүргийг хангуулах	Тухай бүр гүйцэтгэгч байгууллагад шаардлага хүргүүлэн ажиллаж байгаа бөгөөд 2023 онд бүрэн шийдвэрлүүлэх болно.
5	ОНХО	Төсвийн суурь зарлагад батлагдсан 364.8 сая төгрөгийн "Орон нутгийн өмчийн байгууллагуудын засварын ажил" нь батлагдсан зурал төсөл, төсөвгүй	Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4	364,875,800	Шаардлагатай тооцооллыг хийж АИТХ-д танилцуулах	Засвар шаардлагатай байгууллагуудын саналыг нэгтгэн авч, тооцоо судалгаа хийн 2023 оны 1 дүгээр улиралд багтаан Аймгийн Засаг даргын захирамжаар задаргааг батлуулан ажиллана.
Нийт				1,930,653,400		

Орон нутгийн 2023 оны төсөвт зардлыг бууруулах саналд өгсөн хариу тайлбар

№	Байгууллагын нэр	Санал	Үндэслэл	Мөнгөн дүн	Хариу тайлбар
1	АИТХ	Тээвэр шатахууны зардлыг заавар аргачлалын дагуу тооцоогүйгээс илүү гарсан хэсгийг хасах	ЗГ-ын 2019 оны 445-р тогтоолын 3.4.4, Төсвийн тухай хуулийн 6.4.1.	5,638,227	АИТХ-аас ирүүлсэн 2022.11.23-ны өдрийн №281 тоот албан бичгээр ирүүлсэн саналын дагуу өргөн мэдүүлсэн төсөвт нэмж 208.4 сая төгрөгийн зардлын санал ирүүлсэн ба тус зардлаас 128.0 сая төгрөгийг төсөвт тусгаад байна. Шатахуун: 2021, 2022 онуудаас шатахуун, дизель түлшний үнэ, тариф 50-60 хувь нэмэгдсэн. Томилолт: Сангийн сайдын тушаалаар дотоод албан томилолтын тарифт "нэмэгдүүлэх өөрчлөлт" 2022 оны 6-р сарваас эхлэн хэрэгжиж байгаа бөгөөд үүнтэй холбогдуулан нэмсэн. Зочин төлөөлөгч хүлээн авах зардал: Үйл ажиллагаатай холбогдуулан тухайн зардалд зайлшгүй гүйцэтгэл гардаг тул саналын дагуу төсөвлөсөн. БҮБЗ: Мөн адил үйл ажиллагаатай холбогдуулан гэнэтийн аливаа зардлыг санхүүжүүлэх зорилгоор төсөвлөсөн. Биеийн тамирын уралдаан тэмцээн: МУГДасгалжуулагч Л.Цэдэнсодном агсны нэрэмжит Воллейболлын тэмцээнийг АИТХ-ын мөзөл дор жил бүр зохион байгуулж хэвшээд байгаа тул тус зардалд төсөвлөсөн.
2	АИТХ	Дотоод албан томилолтын зардлыг төсвийн суурь зарлагаас даасан хэмжээгээр хасах	Төсвийн тухай хуулийн 6.4.1, 31.1.3, Төрийн хэмжээний тухай хуулийн 15.2.3	5,000,000	
3	АИТХ	Зочин төлөөлөгч хүлээн авах зардлыг төсвийн суурь зарлагаас даасан хэмжээгээр хасах	Төсвийн тухай хуулийн 6.4.1, 31.1.3	3,000,000	
4	АИТХ	Баруун үйлчилгээний бусад зардлыг төсвийн суурь зарлагаас даасан хэмжээгээр хасах, /Хууль журамд нийцдэггүй АИТХ-ын даргын нөөц сан гэсэн арга хэмжээ төлөвлөсөн /	Төсвийн тухай хуулийн 6.4.1, 31.1.3	25,000,000	
5	АИТХ	Биеийн тамир уралдаан тэмцээний зардлыг төсвийн суурь зарлагаас даасан хэмжээгээр хасах	Төсвийн тухай хуулийн 6.4.1, 31.1.3	7,000,000	
6	АЗДТГ	Дотоод албан томилолтын зардлын тайланг оны зардлын дүнгээс илүү гарсан хэсгийг хасах	Төсвийн тухай хуулийн 6.4.1, 31.1.3, Төрийн хэмжээний тухай хуулийн 15.2.3	4,224,000	Сангийн сайдын тушаалаар дотоод албан томилолтын тарифт "нэмэгдүүлэх өөрчлөлт" 2022 оны 6-р сарваас эхлэн хэрэгжиж байгаа бөгөөд үүнтэй холбогдуулан Сангийн ламнаас тус зардлыг хянаж, баталж ирүүлсэн.
7	АЗДТГ	Тээвэр шатахууны зардлыг заавар аргачлалын дагуу тооцоогүйгээс илүү гарсан хэсгийг хасах	ЗГ-ын 2019 оны 445-р тогтоолын 3.4.4, Төсвийн тухай хуулийн 6.4.1,	9,566,094	2021, 2022 онуудаас шатахуун, дизель түлшний үнэ, тариф 50-60 хувь нэмэгдсэн байна. АЗДТГ-ын шатахууны зардал 2022 онд 43.8 сая төгрөг ба Сангийн ламнаас 2023 онд 30.0 сая төгрөгөөр тооцож баталсан, тухайн дүнгээр батлуулахаар төсөлд тусгасан.
8	АЗДТГ	Аймгийн ЗДНХ-ийн суурь зарлагыг 185.0 сая төгрөгөөр нэмэгдүүлсэн. Үүнээс төрийн бус байгууллагатай хамтран ажиллах, үйл ажиллагааг дэмжих зардалд 35.0 сая төгрөгийг төлөвлөсөн нь АЗДНХ-ийн чиг үүрэгт хаммааралгүй хасах	Төсвийн тухай хуулийн 6.4.1, 31.1.3, Сангийн сайдын 2021 оны 81-р тушаалын хавсралтаар батлагдсан журмын 2.1	35,000,000	Тус зардлыг Засаг даргын нөөц санд бус АЗДТГ-ын бусдаар гүйцэтгүүлэх арга хэмжээний зардалд шилжүүлэх санал оруулав
9	ПТК, 3,4.5-р сургууль	Дотуур байрны халаалтын зардлыг төсөвт байгууллагын үнэ тарифаар тооцож төсвийн төсөлд тусгасан байх тарифын дагуу тооцож илүү гарсан зардлыг хасах	Төсвийн тухай хуулийн 6.4.1, Эрчим хүчний зохицуулах хорооны 2018 оны 292 дугаар тогтоолын хавсралтаар батлагдсан "Аж ахуйн хэрэгцээний дүрэм"-ийн 5.3.1	107,277,887	Саналыг зөвшөөрөв.
10	Орон нутгийн хөгжлийн сан	"Хяналт шалхилгаа үнэлгээний мэдээллийн цахим санг нэвтрүүлэх" 100.0 сая төгрөгийн өртөгтэй арга хэмжээ нь орон нутгийн хөгжлийн сангийн чиг үүрэгт хаммааралгүй, ирэхдэйн санал авч эрэмбэлэгдээгүй	Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, 60 дугаар зүйлийн 60.3.6, Сангийн сайдын 2021 оны 86-р тушаалаар батлагдсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.3.2	100,000,000	ОНХС-д тусгахгүйгээр АЗДТГ-ын мэдээлэл, технологийн зардалд шилжүүлэхээр тооцод байна.
11	Орон нутгийн хөгжлийн сан	"Төрийн байгууллагуудад шаардлагатай техник тоног төхөөрөмж худалдан авах" арга хэмжээг дахин 190.0 сая төгрөгөөр төлөвлөсөн бөгөөд уг арга хэмжээний төлөвлөлтийн баримт, тооцоо судалгааг аудитад хамруулаагүй, өөр зх үүсвэртэй давхардуулсан	Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, Сангийн сайдын 2012 оны 244-р тушаалын хавсралтаар батлагдсан "Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам"-ын 6 дугаар зүйлийн 6.3.6, Сангийн сайдын 2021 оны 86-р тушаалаар батлагдсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.1.4	190,000,000	Төрийн байгууллагуудад шаардлагатай тоног төхөөрөмжийг хэрэгцээ шаардлагын хүрээнд жил бүр тусган санхүүжүүлэхээр тооцож төлөвлөсөн. АЗДҮАХ-г төрийн байгууллагуудыг шаардлагатай тоног төхөөрөмжөөр хангана гэсэн зөвлөлт үндэслэл тусгасан.
12	Орон нутгийн хөгжлийн сан, АЗДТГ	ОНХС-нд тусган хэрэгжүүлэх 2 арга хэмжээний зардлаас 3.5 сая төгрөгийг шагнал урамшуулал хэлбэрээр зарцуулахаар төсвийн төсөлд тусгасан	Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5, 60 дугаар зүйлийн 60.3.6, Сангийн сайдын 2021 оны 86-р тушаалаар батлагдсан "Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам"-ын 4 дүгээр зүйлийн 4.3.2, 4.7.3, 4.7.5	3,500,000	Аймгийн Засаг даргын захирамжаар 2023 оны эхэнд задргааг батлуулан хэрэгжүүлнэ. Тухайн үед ОНХС-ийн тус журамд нийцүүлэн төлөвлөхөд анхаарч ажиллах болно.
13	Стандартчлал хэмжил зүйн хэлтэс	Стандартчлал хэмжил зүйн хэлтсийг байгуулах эрх бүхий албан тушаалтны шийдвэр гаргаагүй байхад 100.0 сая төгрөгийн урсгал зардал төлөвлөсөн нь Төрийн хамгааллын тухай хууль, Төсвийн тухай хуульд нийцдэггүй тул зардлыг бууруулах	Төсвийн тухай хуулийн 6.4.1, 31.1.3	100,000,000	Тус хэлтэс нь манай аймагт байдаггүйгэй холбогдуулан зайлшгүй шаардлагын дагуу байгуулахаар 2022 онд Аймгийн Засаг даргын захирамжаар ажлын хэсэг гарган судалгаа хийн ажилласан. Энэийн ээлжинд орон нутагтаа төсвийг нь батлуулж дараагийн шийдвэрүүдийг гаргуулах чиглэлд ажиллах төлөвлөгөөтэй байна.
Нийт				595,206,208	

Орон нутгийн 2023 оны төсөвт орлого нэмэгдүүлэх саналд өгсөн хариу тайлбар

№	Байгууллагын нэр	Санал	Үндэслэл	Мөнгөн дүн	Хариу тайлбар
1	АЗД	Сүүлийн 5 жилийн хугацаанд ААН, орон сууцны түрээсийн метр кватратыг нэмэгдүүлж батлаагүй бөгөөд албан хаагчдын орон сууцны үнийг аймгийн төв 5000, сумын төвд 3000 төгрөгөөр байгууллагыг 7000 төгрөгөөр нэмэгдүүлэх боломжтой	Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3,Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2, 28 дугаар зүйлийн 28.5, Төрийн өмчийн бодлого, зохицуулалтын газрын 2020 оны 49 тогтоол	163,900,000.00	ОНӨГ түрээсийн орлогод тооцоо, судалгаа хийн журам боловсруулахаар ажиллаж байгаа бөгөөд 2023 онд АИТХ-аар хэлэлцүүлэн батлуулахаар бэлтгэж байна.
2		Шивээговь, Баянтал сумд нь 2014 онд батлагдсан үнэ тарифыг мөрдөж байна. Иймд үнэ тарифыг шинэчлэн тогтоосноор орлого нэмэгдэх боломжтой байна.	Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.3, Хог хаягдлын тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.7.1 9 дүгээр зүйлийн 9.1.3, 9.1.4	-	
Нийт				163,900,000	

ШАЛГАГДАГЧ БАЙГУУЛЛАГЫН САНАЛД ӨГСӨН ТАЙЛБАР

Аймгийн Засаг даргын орлогчоос ирүүлсэн аудитын тайланд тусгуулах саналыг хянаж үзээд нотлох баримт болон үндэслэлтэй тайлбар ирүүлээгүй тул саналуудыг хэвээр үлдээж дараах 2 саналыг үндэслэн тайлангийн төсөлд өөрчлөлт оруулсан. Үүнд:

Төсвийн зарлагыг бууруулах санал:

4.Орон нутгийн хөгжлийн сан

➤ Аймгийн 2022 оны орон нутгийн хөрөнгө оруулалтын төсөвт “Төрийн байгууллагуудыг цахимжуулахад шаардлагатай тоног төхөөрөмж, сурагчийн ширээ, сандал худалдан авах” арга хэмжээг **107.4 сая** төгрөгөөр төлөвлөж худалдан авах ажиллагааг зарласан боловч гүйцэтгэгч шалгараагүйн улмаас 2023 онд дамжсан байна. 2023 оны ОНХС-гийн хөрөнгөөр “Төрийн байгууллагуудад шаардлагатай техник тоног төхөөрөмж худалдан авах” арга хэмжээг дахин **190.0 сая** төгрөгөөр төлөвлөсөн бөгөөд уг арга хэмжээний төлөвлөлтийн баримт, тооцоо судалгааг аудитад хамруулаагүй, өөр эх үүсвэртэй давхардуулсан нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1, Сангийн сайдын 2012 оны 244 дүгээр тушаалын хавсралтаар батлагдсан “Орон нутгийн төсвийн төсөл боловсруулах журам”-ын 6 дугаар зүйлийн 6.3.6, Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4 дүгээр зүйлийн 4.1.4 гэж заасныг тус тус зөрчсөн байх тул **190.0 сая** төгрөгөөр зардлыг бууруулах

гэснийг аудитын тайлангийн төсөлд санал авах явцад ирүүлсэн баримтыг үндэслэн зарлага бууруулах саналаас төсвийн үр ашгийг дээшлүүлэх санал болгон өөрчлөлт оруулав.

Төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх санал

Хөрөнгө оруулалтын арга хэмжээ-Орон нутгийн хөгжлийн сан

Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр болон хөрөнгө оруулалтын хөтөлбөр, 2023 оны жилийн төлөвлөгөө зэрэг дунд хугацааны бодлогын баримт бичигт тусгагдаагүй **нийт 142.0 сая төгрөгийн 3** төсөл, арга хэмжээ байна. Үүнд:

Хүснэгт №5 “Бодлогын баримт бичигт нийцээгүй, хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээ”
(сая.төг)

№	Төсөл, арга хэмжээний нэр	Мөнгөн дүн	Тайлбар
1	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд усалгааны худаг гаргах, хашаа барих ажил	112.0	Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан “Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4.1.1-т заасныг зөрчсөн.
3	Онцгой байдлын газрын сургалт мэдээллийн төвийн зураг төсөв боловсруулах ажил	20.0	
4	Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн агуулахын зураг төсөв боловсруулах ажил	10.0	
Нийт		142.0	

(Санал-Бодлогын баримт бичигт нийцүүлэх)

гэснийг “Онгой байдлын газрын сургалт мэдээллийн төвийн зураг төсөв боловсруулах ажил” нь АЗДҮАХ-ийн 4.3.11-т агуулгын хувьд тусгасан гэж үзээд дараах байдлаар өөрчлөлт оруулав.

1. Аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр болон хөрөнгө оруулалтын хөтөлбөр, 2023 оны жилийн төлөвлөгөө зэрэг дунд хугацааны бодлогын баримт бичигт тусгагдаагүй **нийт 122.0 сая төгрөгийн 2** төсөл, арга хэмжээ байна. Үүнд:

Хүснэгт №5 “Бодлогын баримт бичигт нийцээгүй, хөрөнгө оруулалт, төсөл, арга хэмжээ”
(сая.төг)

№	Төсөл, арга хэмжээний нэр	Мөнгөн дүн	Тайлбар
1	“Тэрбум мод” үндэсний хөдөлгөөний хүрээнд усалгааны худаг гаргах, хашаа барих ажил	112.0	Сангийн сайдын 2021 оны 86 дугаар тушаалын хавсралтаар батлагдсан
2	Орон нутгийн өмчийн эд хөрөнгийн агуулахын зураг төсөв боловсруулах ажил	10.0	“Орон нутгийн хөгжлийн сангийн үйл ажиллагааны журам”-ын 4.1.1-т заасныг зөрчсөн.
Нийт		122.0	

(Санал-Бодлогын баримт бичигт нийцүүлэх)